



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 1/104

Хажуу шинэ ус


Хорио цээрийн дэглэмийг цуцлаж
хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Малын эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Ажирхай багийн нутаг "Элгэн"-д малын гоц халдварт мялзан өвчин оношлогдож сүүлийн мал эдгэснээс хойш мал нэмэгдэж өвчлөөгүй тул хорио цээрийн дэглэмийг цуцалж хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Хязгаарлалтын бүсэд байгаа малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, ариутгал, халдваргүйтгэл хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж), Угтаал чандмань хоршоо мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Д.Амгалан) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

482201104